



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 45 болон 46 дэх долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 11-р сарын 01-өөс 11-р сарын 12-ны байдлаар

Ковид-19 цар тахлын эдийн засаг, санхүүгийн зах зээлд нөлөөлж буй нөлөөллийн эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 27 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Евростатын урьдчилсан тооцоогоор **Евро бүсийн эдийн засаг 2020 оны 3-р улиралд өмнөх улирлаасаа 12.7 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар агшлаа.** Голлох эдийн засгуудыг дурдвал Испанийн эдийн засаг өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар, Францын эдийн засаг 4.3 хувиар, Италийн эдийн засаг 4.7 хувиар, Германы эдийн засаг 4.2 хувиар тус тус агшжээ.
- **Европын Төв банкны Ерөнхийлөгч К.Лагард "Эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд бодлогын хүүг бууруулах арга хэмжээнээс илүүтэй бонд худалдан авах хөтөлбөр болон урт хугацааны санхүүжилтийн хэрэгсэлд түлхүү анхаарч ажиллана."** гэж мэдэгдлээ. Тэрээр эдийн засгийг дэмжих олон арга байгаа хэдий ч дээрх хоёр арга хэмжээг Төв банкны мөнгөний бодлогын гол арга хэрэгсэл хэвээр үлдээхээ онцоллоо. Евро бүсэд КОВИД-19-ийн хоёр дахь давалгаа дэгдсэнтэй холбоотойгоор эдийн засгийн нөхцөл байдал сулраад байгаа энэ үед эдийн засгийн сэргэлт тогтворгүй байх эрсдэлтэйг мөн сануулжээ. Европын Төв банк 12 дугаар сард болох хурлаараа 1.6 их наяд ам.долларын бондын хөтөлбөрөө өргөжүүлэх тухай хэлэлцэх хүлээлттэй байна.
- **АНУ-ын ХНБ 11-р сарын 5-ны хурлаар бодлогын хүүгээ 0 орчимд хэвээр үлдээж, сард 120 орчим тэрбум ам.долларын бонд худалдан авалтын хөтөлбөрөө** яг энэ түвшинд нь **үргэлжлүүлэхээ зарлажээ.** АНУ-ын ХНБ-ны тэргүүн Ж.Повел "Эдийн засгийн сэргэлт алгуур үргэлжлэх бөгөөд Ковид-19-ийн тархалт өндөр хэвээр энэ үед төсвийн нэмэлт дэмжлэг шаардлагатай" гэж онцолсон байна. ХНБ-ны Бодлогын зөвлөл дараагийн ээлжит хурлаа ирэх сарын 15-16-нд хийнэ.
- Эдийн засгаа дэмжих бодлогын хүрээнд **Английн Төв банкнаас бонд худалдан авах хөтөлбөрөө 195 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэхээр болжээ.** Ингэснээр бонд худалдан авах хөтөлбөрийн дүн нийтдээ 1.1 их наяд ам.долларт хүрээд байна. Энэхүү хөтөлбөр нь 2021 оны эхнээс эхэлж, 2021 оныг дуустал үргэлжлэх төлөвтэй байна. Харин Английн Төв банкны ерөнхийлөгчийн мэдээлснээр Төв банк бодлогын хүүгээ 0.1 хувьд хэвээр хадгалахаар болсон байна. Төв банк 3-р сараас хойш мөнгөний бодлогын төлөвийг 4 удаа зөөлрүүлээд байгаа



бөгөөд оны сүүлийн улиралд Английн эдийн засаг 2 хувиар агших төлөвтэй байгаа аж.

- J.P. Morgan дэлхийн үйлдвэрлэлийн PMI индекс 10-р сард 53 болж сүүлийн 29 сарын хамгийн өндөр түвшинд хүрснийг танилцууллаа. АНУ болон Европт цар тахлын хоёр дахь давалгаа дэгдсэн хэдий ч үйлдвэрлэлийн салбар харьцангуй сайн байгаа нь эрэлт харьцангуй өндөр, нийлүүлэлт тасалдаагүй байгаатай холбоотой. Дэлхийн PMI индексийг дэд индексүүдээр авч үзвэл хамгийн өндөр нь үйлдвэрлэл (output), шинэ захиалга (new orders), ирээдүйн хүлээлт (future expectations) зэрэг байсан бол хамгийн сул нь экспортын захиалга (export orders), ажил эрхлэлт (employment), бүтээгдэхүүний үнэ (output prices) байлаа.

Улс орнуудаар авч үзвэл АНУ-ын PMI индекс 53.4 болж сүүлийн 2 жилийн дээд түвшинд хүрсэн бол Канадын PMI индекс 55.5-д хүрсэн өмнөх саруудаас бага зэрэг буурсан дүн боллоо. Европын PMI индекс 54.8 болж сүүлийн 27 сарын дээд түвшинд хүрлээ. Азид Энэтхэгийн PMI индекс 58.9 болж сүүлийн 10 жилийн дээд түвшинд

хүрчээ. Энэтхэгт үйлдвэрлэл сүүлийн 12 жилийн дээд хэмжээнд хүрч, экспортын захиалга сүүлийн 6 жилийн дээд түвшинд хүрсэн байна. БНХАУ-ын PMI индекс 53.6 болж 2011 оны 1 дүгээр сараас хойших хамгийн дээд түвшинд хүрсэн байна. Харин Японы PMI индекс бусад орнуудаас бага буюу 48.7 байсан ч энэ нь 1 дүгээр сараас хойшхи дээд түвшин боллоо.

- БНСУ-ын ажилгүйдлийн түвшин 10-р сард 4.2 хувьд хүрсэн нь сүүлийн 3 сарын дээд түвшинд боллоо. Мөн КОВИД-19-ийн бизнес эрхлэгчдэд учруулж буй дарамтын нөлөөгөөр ажил эрхэлж буй хүмүүсийн тоо 10-р сард 27.1 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 421 мянгаар буурч, сүүлийн 6 сарын туршид тасралтгүй хурдтай буурсан үзүүлэлт болжээ.

Эх сурвалж:

1. Bloomberg, [Legarde Says Next Stimulus to Rely on Emergency QE, Loans](#)
2. JP Morgan, [Global manufacturing output and new orders accelerate at start of fourth quarter](#)
3. New York times, [Federal Reserve Meets Amid Major Uncertainties](#)
4. Reuters, [South Korea Oct.unemployment rate rises: jobs pace in 6 mths](#)
5. The Wall Street Journal, [Bank of England Boosts Stimulus as U.K Battles Second Wave of Covid-19](#)
6. Deloitte Insights, [Weekly global economic update November 2020](#)

- Дэлхийн банк 10-р сарын тайландаа БНХАУ-ын эдийн засаг 2020 онд 2.0 хувиар, 2021 онд 7.9 хувиар өсөхөөр төсөөлжээ¹. Энэ онд БНХАУ-ын Засгийн газрын зарцуулалт тэлж, экспорт нэмэгдэж байгаа, КОВИД-19-ийн тархалт 3-р сараас хойш бага

түвшинд байгаа зэрэг нь өсөлтөд эерэг нөлөөтэй боловч хувийн хэрэглээний сэргэлт алгуур байхаар байна. Харин ОУВС-аас БНХАУ-ын эдийн засгийг ирэх онд 8.2 хувиар, Блүмбергийн эдийн засагчид 8.1 хувиар өснө гэж төсөөлж байна.

¹ Дэлхийн банк БНХАУ-ын энэ оны өсөлтийн төсөөллийг 6-р сард 1.0 хувь гэж төсөөлж байсан юм.



- БНХАУ-ын Гаалийн Ерөнхий газрын мэдээллээр БНХАУ-ын гадаад худалдааны тэнцэл 2020 оны 9-р сард 37 их наяд юань байсан бол **10-р сард 58.4 их наяд юаньд хүрч нэмэгдлээ.** БНХАУ-ын экспорт энэ оны 9-р сард жилийн 9.9 хувиар өссөн бол 10-р сард өсөлт эрчимжиж, 11.4 хувиар өслөө. Энэ нь Блүмбергийн шинжээчдийн хүлээлт 9.2 хувиас давсан үзүүлэлт болов. Экспортын гол түнш болох АНУ, Евро бүс, Азийн орнууд руу экспорт нэмэгдэж, ялангуяа эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүд болон электрон барааны экспорт өндөр байв. Харин АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан ширүүсэн, бараа материалын нөөцлөлт нэмэгдсэн нөлөөгөөр 2020 оны 9-р сард жилийн 13.2 хувиар огцом өссөн БНХАУ-ын импортын өсөлт 10-р сард саарч, жилийн 4.7 хувиар өсчээ. Австрали, Хятадын таагүй харилцаа үргэлжилж, Австралиас импортлосон нүүрсний импорт 10-р сард 47 хувиар буураад байгаа хэдий ч бусад барааны импорт өсч, Австралиас авсан нийт импорт өнгөрсөн сард 6.6 хувиар нэмэгджээ.
- **БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн тэлэлт үргэлжлэв.** БНХАУ-ын аж үйлдвэрийн Caixin PMI индекс 10-р сард хүлээлтээс давж 53.6 хүрсэн бол БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс 10-р сард 51.4 хүрч 8 дахь сардаа тэлэлт үргэлжиллээ². Үүнд аж үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт аль аль нь сэргэсэн нь нөлөөлжээ. Бизнесийн үйл ажиллагаа сайжирч, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэж байгаа тул үйлдвэрлэл эрхлэгчид нөөцөө нэмэгдүүлэх сонирхолтой байна. Дэд индексүүдээр задалж харвал шинэ экспортын захиалга нэмэгдсэн ч

ажил эрхлэлтийн бүрэлдэхүүн индекс 50-аас доогуур түвшинд хадгалагдсан хэвээр байна.

- **БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн бус салбар сэргэж байна.** БНХАУ-ын аж үйлдвэрийн бус албан ёсны PMI индекс 9-р сард 55.9-өөс 10-р сард 56.2 хүрч нэмэгдэв. Үүнд үйлчилгээний салбарын сэргэлт нэмэгдэн PMI 55.5 хүрч өсөв. Үүнд засгийн газрын барилгын салбарыг дэмжих бодлогын нөлөөгөөр барилгын салбарын өсөлт хадгалагдсан нь нөлөөлөв.
- **БНХАУ-ын эдийн засаг ирэх 5 жилд дунджаар 5.5 хувиар өсөх, түүнээс цааш 2035 оныг хүртэл жилд дунджаар 5.0 хувиар өсөх боломжтой** гэж Chongqing-ийн захирагч асан Huang Qifan мэдэгдлээ. Тэрээр БНХАУ дотоод эрэлтийг дэмжиж, гадаад эдийн засгаас хараат байдлыг бууруулах, ялангуяа түүхий нефтээс хараат байдлаа бууруулах зорилтыг “dual circulation” өсөлтийн стратегийн хүрээнд тавьж байгааг онцоллоо. БНХАУ одоогоор нефтийн хэрэглээнийхээ 70 хувийг импортоор хангадаг бөгөөд импортын хэрэглээг 10-20 хувиар бууруулахыг зорьж байгаа юм.
- **БНХАУ-ын нүүрсний импорт 10-р сард 13.7 сая тонн болж өмнөх сараас 27 хувиар, өмнөх оны мөн үеэс 47 хувиар буурав.** Үүнд БНХАУ, Австралийн таагүй харилцаа 10-р сарын турш үргэлжилж, Австралиас импортлох БНХАУ-ын нүүрсний импорт огцом буурсан нь нөлөөлжээ. Refinitiv байгууллагын мэдээлснээр далайн тээврээр импортлосон нүүрсний экспорт 10 сая тонн байсан бол газрын тээврээр хийгдсэн импортын дийлэнхийг Монгол Улс бүрдүүлсэн

² БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индексийн түүвэр судалгаанд том үйлдвэрүүд, төрийн өмчит компаниудыг түлхүү хамруулдаг бол CAIXIN

PMI индекст жижиг, дунд үйлдвэрүүдийг илүү их жинтэйгээр хамруулан судалдаг. PMI индекс 50-аас дээш утга авах нь тэлэлтийг илтгэнэ.



байна. Монголын гаалийн статистик мэдээллээр 10-р сард Монголын нүүрсний экспорт 4.04 сая тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар нэмэгдээд байна.

Эх сурвалж:

1. Mining & Quarry World, [China coal imports show the pain goes beyond just Australia](#)
2. Australian Mining, [China coal imports from Australia cut in half](#)

3. China Briefing, [World Bank October 2020 Report Says China Economy to Grow by 7.9% in 2021](#)
4. South China Morning Post, [China's economic recovery powers on as manufacturing, services sectors remain strong](#)
5. South China Morning Post, [China GDP growth least 5.5 cent annually next 5 years](#)
6. South China Morning Post, [China's exports surged unexpectedly last month, as pace of import growth cooled off](#)

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улс, БНХАУ-ын засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн хуралдаан боллоо. Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар даргалав. Энэ үеэр комиссын хуралдааны бэлтгэлийг эрчимжүүлэх, хуралдааны үеэр манай талаас дэвшүүлэх санал, илэрхийлэх байр суурийг хэлэлцлээ. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, БНХАУ-ын засгийн газар хоорондын комисс нь Монгол, БНХАУ-ын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцдэг гол механизм билээ. Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг хоёр жилд тутамд зохион байгуулдаг. Энэ удаагийн Комиссын 16 дугаар хуралдаан Монгол Улсад болох байсан хэдий ч “КОВИД-19” цар тахлын улмаас цахим хэлбэрээр зохион байгуулсан юм. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны явцад гарсан ололт амжилтыг дүгнэх, ойрын хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх гол зорилт, томоохон арга хэмжээ, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, өндөр дээд түвшний айлчлалын үеэр тохирсон худалдаа, эдийн засгийн хамтын

ажиллагааны талаарх тохиролцоо, хэрэгжүүлж буй томоохон төсөл, арга хэмжээний явцыг түргэтгэхэд ач холбогдолтой юм.

УИХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг эцсийн хэлэлцүүлгээр хэлэлцүүлж баталлаа. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг энэ онд агшиж, цаашид сэргэх хугацаа одоогоор тодорхой бус хэвээр байна. Энэ нь их хямралаас хойших хамгийн огцом уналт болж, улс орон бүр эдийн засгийн хүндрэл, сорилттой нүүр тулж байна. Дотоод эдийн засаг 2017-2019 онуудад сэргэж, тогтворжсон хэдий ч, Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээний нөлөөгөөр эдийн засагт оролцогчдын хүлээлт өөрчлөгдөж, бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаас болж эдийн засаг эхний хагас жилд 9.7 хувиар агшаад байна. Энэ үед Монголбанк эдийн засгийн уналтаас иргэд, аж ахуйн нэгж, банкны системийг хамгаалах, үүссэн шокыг зөөлрүүлэх зорилгоор i) зах зээл дээрх хөрвөх чадварыг дэмжиж, санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх, ii) банкны хяналт шалгалтын журам

болон шалгуур үзүүлэлтүүдэд түр тохируулга хийх, өөрчлөлт оруулах, iii) зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах зэрэг мөнгөний бодлого, макро зохистой бодлого болон микро зохистой бодлогын багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Ирэх онд Төв банк хуулиар ногдсон үндсэн зорилгоо хангах, цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг хохирол багатай даван туулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай бодлогын арга, хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд эрх бүхий төрийн байгууллага болон олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн чуулга уулзалтаар Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтаас гаргахаар шийдвэрлэснийг ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер албан захидлаар мэдэгдэж, баяр хүргэлээ. Түүний захидалд “Цар тахлын хүнд хэцүү цаг үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсанд баяр хүргэе. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, дутагдлыг арилгах чиглэлээр дараах гол арга хэмжээг авч хэрэгжүүлснийг ФАТФ-аас сайшаан үнэлж байна. Үүнд: i) Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх,


мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулж ажилласан; ii) тодорхойлсон эрсдэлтэй нь уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлсэн; iii) хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээг авсан; iv) хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулснаас гадна санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн терроризм болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авсан. Иймд Монгол Улс үйл ажиллагааны төлөвлөгөөгөө бүрэн биелүүлэн, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, цаашид тогтвортой хэрэгжүүлэхээр байгаа газар дээрх хяналт шалгалтаар баталгаажуулсны үр дүнд Монгол Улсыг ФАТФ-ын хяналтаас гаргахаар шийдвэрлэлээ. Монгол Улсын гаргасан ахиц дэвшлийн талаар болон ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргах тухай шийдвэрийг ФАТФ-ын цахим хуудсанд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр нийтэлсэн болно. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байгаа явдалд дахин баяр хүргэе” гэжээ.



4 МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/11/12	Өөрчлөлт				YoY	
		daily	weekly	monthly	year to date		
Зэс	6915.8	0.0%	1.1%	2.8%	12.2%	19.0%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй байна гэсэн мэдээнээс зэсийн үнэ бага зэрэг нэмэгдээд байна.
Төмрийн хүдэр	114.7	0.0%	3.5%	-2.4%	30.1%	51.1%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөвтэй бөгөөд коксжих нүүрсний эрэлт 11-р сард өндөр байхаар байгаа нь үнэ нэмэгдэхэд нөлөөлж байна.
Алт	1876.8	0.1%	-3.7%	-2.3%	22.9%	27.7%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины эхний шатны туршилт 90 хувийн үр дүнтэй байна гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны өндөр үнэ өмнөх долоо хоногоос буурахад нөлөөлөв.
Газрын тос (Брент)	43.5	-1.3%	8.9%	3.0%	-35.2%	-31.1%	КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай зэрэгцээд газрын тосны үнэ буурч байна. Гэсэн хэдий ч “Pfizer” вакцины туршилт амжилттай болж буй мэдээ үнийг өмнөх долоо хоногоос нэмэгдэхэд нөлөөлөв. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ





Эх сурвалж: Блүүмберг